



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/293

Улаанбаатар хот

Худалдан авах ажиллагааны
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/292 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, тайлагнахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Бямбадагва/, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга /Л.Баярмандал/, Үндэсний геологийн албаны дарга /О.Чулуун/ нарт тус тус даалгасугай.

3.Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Мөнхдөл/-т үүрэг болгосугай.

САЙД



Ж.ГАНБААТАР

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 81 дугаар тушаалын хавсралт

Үндэсний геологийн алба							
III.	Тендер шалгаруулалтын код	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр, нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Төрөл (бараа, ажил, зөвлөх үйлчилгээ, зөвлөхөөс бусад үйлчилгээ)	Төсөвт өртөг (мян.төг)	Тухайн онд санхүүжих дүн (мян.төг)	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, арга	Тендер зарлах огноо
							Тайлбар, тодруулга
1	Урсгал төсөв						
	Хангамж бараа материалын зардал						
1.1.		Бичиг хэрэг	Бараа	34,298.2	34,298.2	ХА	2023.01.18
1.2		Тээвэр шатахуун	Бараа	6,591.8	6,591.8	ШХА	-
1.3		Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	Бараа	5,887.1	5,887.1	ШХА	-
1.4.		Багаж, техник, хэрэгсэл	Бараа	18,210.3	18,210.3	ШХА	
1.5.		Хөдөлмөр хамгаалал	Бараа	3,301.5	3,301.5	ШХА	-
1.6.		Урсгал засвар	Бараа	30,797.0	30,797.0	ШХА	Тухай бүр худалдан авалтыг хийнэ
	Дүн			99,085.9	99,085.9		
2	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ						
2.1		Харуул хамгаалалт	ЗБУ	19,623.60	19,623.60	ШХА	-
2.2		Даатгалын үйлчилгээ	ЗБУ	6,192.8	6,192.8	ШХА	-
2.3		Мэдээллийн технологийн үйлчилгээ	ЗБУ	31,375.5	31,375.5	ХА	2023.02.10
	Дүн			57,191.9	57,191.9		
3	Геологийн судалгааны аргачлал, хяналтын зардал						
		Геологийн судалгааны ажлын гүйцэтгэл, тайлан төлөвлөгөөг цахимаар хүлээн авах системийн хөгжүүлэлт	ЗУ	49,000.0	49,000.0	БҮА	2023.02.27
		Геологийн заавар, зөвлөмж боловсруулах	ЗУ	45,000.0	45,000.0	БҮА	2023.02.27
		Геофизикийн ажлуудын норм, нормчлол боловсруулах	ЗУ	45,000.0	45,000.0	БҮА	2023.02.27
		1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлаар хийгдэх бүх төрлийн сорьцолтын ажлын зардлын норм, нормчлол боловсруулах	ЗУ	50,000.0	50,000.0	БҮА	2023.02.27
	Дүн			189,000.00	189,000.00		
	НИЙТ ДҮН			345,277.80	345,277.80		